



**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 30 өдөр

Дугаар A/592

Есөнбулаг

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/161 дүгээр тушаал, аймгийн Онцгой комиссын 2023 оны 19 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Онцгой комиссын 2023 оны 19 дүгээр хурлын шийдвэрийн дагуу галзуу өвчний сэжигтэй тохиолдлоор нас барсан иргэний оршуулгын ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Мөнхзул	(Зоонозын өвчин судлалын төвийн тархвар судлаач эмч)
Гишүүд	Б.Хоролгарав	(Зоонозын өвчин судлалын төвийн ариутгагч)
	Х.Төгсбилэг	(Зоонозын өвчин судлалын төвийн жолооч)
	М.Алтансүх	(Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах салбарын бүлгийн дарга, аврах ажиллагааны зааварлагч, ахлах дэслэгч)
	Ү.Сосорбурам	(Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах салбарын аврагч-жолооч, холбоочин, дэд ахлагч)
	Д.Төмөрчөдөр	(Есөнбулаг сумын хэсгийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч)
	А.Жаргалсайхан	(Цагдаагийн газрын Хэв журмын тасгийн эргүүлийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч)
Нарийн бичгийн дарга:	М.Энхмандах	(Зоонозын өвчин судлалын төвийн ариутгагч)

2. Захирамжийн хэрэгжилтийг хангуулж, галзуу өвчний сэжигтэй тохиолдлоор нас барсан иргэнийг орцуулах үйл ажиллагааг хуулийн хүрээнд удирдан зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Мөнхзул)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР